



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/82

Арвайхээр

Тендер хүчингүй болгож, дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Арвайхээр суманд нийтийн тээврийн зориулалттай дунд оврын автобус нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх хүчингүй болсон тендерийг холбогдох хууль, журмын дагуу дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100134